



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/44

Мандалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Дэлгэрхангай сумын 1,2,3,4 дүгээр багт мал угаалгын ванн шинээр барих ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Буманбаатар	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Баатарсүрэн	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	Ё.Эрдэнэбулган	(Дэлгэрхангай сумын Засаг даргын тасгын газрын Мал эмнэлэг үржлийн тасгийн эрхлэгч)
	Х.Анхбаяр	(Гүйцэтгэгч “Хангда” ХХК-ийн менежер)
	Т.Уранбайгаль	(Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Б.Буманбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЧАГНААДОРЖ

D/ Alban bichig/ Tushaal 2024.09.18
484010167